



**БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН
АУДИТЫН ГАЗАР**

Гүйцэтгэлийн аудитын тайлан

**АЙМГИЙН ИТХ-ААС БАТАЛСАН ДЭД ХӨТӨЛБӨРҮҮДИЙН
ХЭРЭГЖИЛТ ТӨЛӨВЛӨСӨН ҮР ДҮНД ХҮРЭЭГҮЙ БАЙНА**

**2023 оны 10
дугаар сар**

**АУДИТЫН СЭДЭВ: АЙМГИЙН ИТХ-ААС БАТАЛСАН
ТӨСӨЛ, ХӨТӨЛБӨРҮҮДИЙН ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН**

2023 он

АГУУЛГА

АГУУЛГА	2
Товчилсон үгийн тайлбар	3
Хүснэгтийн товъёг	4
Графикийн товъёг	4
Аудитын зорилт, хамарсан хүрээ, стандарт, арга зүйн талаарх мэдэгдэл	5
А. АЙМГИЙН ИТХ-ААС ДЭД ХӨТӨЛБӨРҮҮДИЙГ ХУУЛЬ, ЖУРАМД НИЙЦҮҮЛЭН БАТАЛСАН БАЙНА	7
А.1. Аймгийн ИТХ-аас баталсан дэд хөтөлбөрүүд хууль журам, бодлогын баримт бичигтэй нийцсэн байна	7
А.1.1. Аймгийн ИТХ-аас холбогдох хууль журамд нийцсэн дэд хөтөлбөрүүдийг баталсан байна	7
А.1.2. Аймгийн ИТХ-аас баталсан дэд хөтөлбөрүүд дунд болон богино хугацааны бодлогын баримт бичигтэй нийцсэн байна	8
А.2. Дэд хөтөлбөрүүдэд шаардагдах төсвийг үндэслэлтэй төлөвлөөгүй боловч хэрэгжүүлэх нөхцөл бүрдсэн байна	9
А.2.1. Дэд хөтөлбөрүүдэд шаардагдах хөрөнгийн эх үүсвэрийг үндэслэлтэй төлөвлөөгүй байна	9
А.2.2. Аймгийн ИТХ-аас баталсан дэд хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө гаргаагүй байна	9
Б. АЙМГИЙН ИТХ-ААС БАТАЛСАН ДЭД ХӨТӨЛБӨРҮҮДИЙН ХЭРЭГЖИЛТ ХАНГАЛТГҮЙ БАЙНА	10
Б.1. Дэд хөтөлбөрүүдийн хэрэгжилт төлөвлөсөн үр дүнд хүрээгүй байна	10
Б.1.1. Дэд хөтөлбөрүүдэд баталсан санхүүжилтийг дутуу олгосон байна	10
Б.1.2. Дэд хөтөлбөрүүдэд төлөвлөсөн арга хэмжээний 59.5 хувийг хэрэгжүүлсэн байна	10
Б.2. Дэд хөтөлбөрүүдэд хяналт шинжилгээ, үнэлгээ хийсэн боловч үр дүнг тооцоогүй байна	12
Б.2.1. Дэд хөтөлбөрүүдийн үр дүнг бодитой тайлагнаагүй байна	12
Б.2.2. Дэд хөтөлбөрүүдийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн байна	13
Б.2.3. Дэд хөтөлбөрүүдийн хэрэгжилтэд хяналт тавьж ажилласан байна	14
Б.2.4. Дэд хөтөлбөрийн хэрэгжилт, үр дүнгийн талаар олон нийтэд мэдээлж ажилласан байна	15
ДҮГНЭЛТ:	17
ЗӨВЛӨМЖ:	17
ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГЫН САНАЛ	18

Товчилсон үгийн тайлбар

МУЕА	Монгол Улсын Ерөнхий аудитор
АДБОУС	Аудитын дэд байгууллагын олон улсын стандарт
СӨБ	Сургуулийн өмнөх боловсрол
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
ХШҮХ	Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтэс

Хүснэгтийн товьёг

Хүснэгт 1	Аймгийн ИТХ-аас баталсан дэд хөтөлбөрүүд салбараар	7
Хүснэгт 2	Дэд хөтөлбөрүүдийн эх үүсвэрийн төлөвлөлт, олгосон санхүүжилт, зарцуулалт	10
Хүснэгт 3	Дэд хөтөлбөрүүдийн зорилт, арга хэмжээ	13
Хүснэгт 4	Мэдээллийн ил тод байдлын судалгаа	15

Графикийн товьёг

График 1	Аймгийн ИТХ-аас баталсан дэд хөтөлбөрийн судалгаа	7
----------	---	---

Аудитын зорилт, хамарсан хүрээ, стандарт, арга зүйн талаарх мэдэгдэл

Аудит хийх үндэслэл, бүрэн эрх	Аудитыг Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3 дэх хэсгийн 6.3.1-д заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Монгол Улсын Ерөнхий аудиторын 2023 оны А/04 дүгээр тушаалаар баталсан “Аудитын жилийн төлөвлөгөө”, Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газрын 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг үндэслэн хийв.
Аудитын зорилт	Аймгийн ИТХ-аас баталсан төсөл, хөтөлбөрүүдийн хэрэгжилт, үр дүнд гүйцэтгэлийн аудит хийж, дүгнэлт өгч, зөвлөмж боловсруулан аймгийн ИТХ болон холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулахад аудитын зорилго чиглэгдэв. Аудитын зорилгыг хангахын тулд дараах чиглэлээр аудитыг гүйцэтгэв.Үүнд: • Аймгийн ИТХ-аас үр дүнтэй төсөл, хөтөлбөрүүдийг баталсан эсэх, • Аймгийн ИТХ-аас баталсан төсөл, хөтөлбөрийн хэрэгжилт, тайлагнал, хяналт үр дүнтэй эсэх
Аудитын хамарсан хүрээ	Аймгийн ИТХ-аас 2018-2022 онд дэд хөтөлбөрүүдийг баталсан тогтоол, Аймгийн ИТХ-ын төсөв баталсан тогтоол, дэд хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө, холбогдох байгууллагуудын ажлын тайлан, баримт материалууд, хөтөлбөрийг хэрэгжүүлэгч байгууллагуудын санхүүгийн болон үйл ажиллагааны тайлан зэрэг материал хамрагдана.
Аудитын хязгаарлалт	Байхгүй
Аудитын арга зүй, шалгуур үзүүлэлт	Аудитыг гүйцэтгэлийн аудитын стандарт АДБОУС 100, 300, 3000-3100, Монгол Улсын Төрийн аудитын стандарт, MNS 6817-1:2020 “Төрийн аудит.Тулгуур зарчим”, MNS 6817-2:2020 “Төрийн аудит.Ёс зүйн дүрэм”, MNS 6817-3:2020 “Төрийн аудит.Чанарын хяналт”, MNS 6817-5:2020 “Гүйцэтгэлийн аудитын тулгуур зарчим”, MNS 6817-6:2020 “Нийцлийн аудитын тулгуур зарчим”, МУЕА-ын 2020 оны А/106 дугаар тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам”, 2021 оны А/69 дүгээр тушаалаар баталсан “Гүйцэтгэлийн аудитын заавар, аргачлал”-ыг ашиглан гүйцэтгэв. Асуудлыг шинжлэхдээ Төрийн аудитын стандарт, гүйцэтгэлийн заавар, аргачлалд тусгагдсан аудитын арга зүйг ашиглан холбогдох байгууллагын эрх бүхий албан тушаалтан, мэргэжилтнүүдтэй ярилцлага хийх, баримт материалыг шалгах, асуулга лавлагаа авах, харьцуулах, дүн шинжилгээ хийх, аудитын төлөвлөгөө, хөтөлбөр, горимын дагуу нотлох зүйл

**Аудитын
бүрэлдэхүүн,
хугацаа**

цуглуулж, дүн шинжилгээ хийж аудитын дүн, дүгнэлт, зөвлөмж боловсруулав.

Аудитыг Баян-Өлгий аймаг аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудиторын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Х.Женисбек хянан удирдаж, чанарын хяналтыг хэрэгжүүлж, ахлах аудитор М.Айнур аудитын багийг ахалж, аудитор Х.Манаргүл, Б.Үүрийнтуяа, Ж.Назгүл, Х.Еркебулан, С.Нурлан нарын бүрэлдэхүүнтэй баг 2023 оны 9 дүгээр сарын 06-ны өдрөөс ажлын 36 хоногт багтаан хийж гүйцэтгэв.

Аудитын төлөвлөлтийн үе шатны ажлыг 2023 оны 09 дүгээр сарын 04-нээс 09 дугаар сарын 11-ний хооронд хийж, талбарын ажлыг 9 дүгээр сарын 12-ноос 10 дугаар сарын 19-ны хооронд хэрэгжүүлж, аудитын тайланг 10 дугаар сарын 19-нээс 10 дугаар сарын 25-ны хооронд бэлтгэж, хянуулан батлуулав.

Хүндрэл бэрхшээл

байхгүй

А. АЙМГИЙН ИТХ-ААС ДЭД ХӨТӨЛБӨРҮҮДИЙГ ХУУЛЬ, ЖУРАМД НИЙЦҮҮЛЭН БАТАЛСАН БАЙНА


А.1. Аймгийн ИТХ-аас баталсан дэд хөтөлбөрүүд хууль журам, бодлогын баримт бичигтэй нийцсэн байна

А.1.1. Аймгийн ИТХ-аас холбогдох хууль журамд нийцсэн дэд хөтөлбөрүүдийг баталсан байна

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд заасан Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын бүрэн эрх, чиг үүргийг аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2018-2022 оны 32 удаагийн тогтоолоор нийт 37 дэд хөтөлбөрийг хэрэгжүүлэхээр баталсан байна.

Дэд хөтөлбөрүүдийг 1-4 жилийн хугацаанд хэрэгжүүлэхээр 185 зорилт, 944 арга хэмжээний хүрэх үр дүн, шалгуур үзүүлэлтийг тодорхойлж, хэрэгжүүлэгч салбар, байгууллагуудыг баталсан байна.

График №1 Аймгийн ИТХ-аас баталсан дэд хөтөлбөрийн судалгаа



Эх сурвалж: Аймгийн ИТХ-ын дэд хөтөлбөр баталсан тогтоолууд

Аймгийн ИТХ-аас 2018 онд 5, 2019 онд 11, 2020 онд 5, 2021 онд 1, 2022 онд 15 дэд хөтөлбөр тус тус баталсан байна.

Аймгийн ИТХ-аас 2018-2022 онуудад баталсан дэд хөтөлбөрүүдийг салбараар нь авч үзвэл боловсролын салбарт 29.7 хувь буюу 11, хууль эрх зүйн салбарт 18.9 хувь буюу 7, хүнс, хөдөө, аж ахуй салбарт 16.2 хувь буюу 6, эрүүл мэндийн салбарт 13.5 хувь буюу 5, Нийгмийн хамгаалалын салбарт 10.8 хувь буюу 4 хөтөлбөр баталсан нь нийт дэд хөтөлбөрийн 89.1 хувийг эзэлж байна.

Байгаль орчин, соёл урлаг, эрчим хүч, цахим технологийн салбарт тус бүр нэг дэд хөтөлбөр баталсан нь нийт дэд хөтөлбөрийн 10.8 хувийг эзэлж байна.

Хүснэгт №01 Аймгийн ИТХ-аас баталсан дэд хөтөлбөрүүд салбараар

№	Салбараар	Дэд хөтөлбөрийн тоо	Эзлэх хувийн жин
1	Боловсрол	11	29.7
2	Хууль эрх зүй	7	18.9
3	Хүнс, хөдөө, аж ахуй	6	16.2
4	Эрүүл мэнд	5	13.5

5	Нийгмийн хамгаалал	4	10.8
6	Байгаль орчин	1	2.7
7	Соёл урлаг	1	2.7
8	Эрчим хүч	1	2.7
9	Цахим технологи	1	2.7
	Дүн	37	100.0

Эх сурвалж: Аймгийн ИТХ-ын дэд хөтөлбөр баталсан тогтоол

Дээрх хүснэгтээс үзэхэд аймаг орон нутаг, тухайн салбаруудад шаардлагатай дэд хөтөлбөрүүдийг баталсан байна.

А.1.2. Аймгийн ИТХ-аас баталсан дэд хөтөлбөрүүд дунд болон богино хугацааны бодлогын баримт бичигтэй нийцсэн байна

Монгол Улсын Их Хурлаас Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуулийг 2015 оны 11 дүгээр сарын 26-ны өдөр баталсан бөгөөд 2020 оны 05 дугаар сарын 07-ны өдөр Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болгон шинэчлэн найруулж баталсан байна.

Аудитын хамрах хугацаанд “Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хууль”, “Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль” тус тус хамаарч байна.

Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.12 дахь заалтад “хөгжлийн бодлогын баримт бичиг” гэж үндэсний, салбарын, салбар хоорондын болон бүс нутаг, аймаг, нийслэлийн түвшинд, урт, дунд, богино хугацааны зорилго, зорилт, хэрэгжүүлэх арга зам, хүрэх үр дүн, шалгуур үзүүлэлтийг тусгасан, эрх бүхий этгээдээс баталсан энэ хуулийн 4.1.1-4.1.11-д заасан баримт бичиг гэж тодорхойлжээ.

Харин 2020 онд шинэчлэн баталсан Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулиар дэд хөтөлбөрүүдийг баталж, хэрэгжүүлэх тухай заагаагүй бөгөөд тус хуулийн 9 дүгээр зүйлийн 9.10.1-д “Монгол Улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлд нийцүүлэн Аймаг, нийслэл, хотыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, Аймаг, нийслэл, хотын хөгжлийн жилийн төлөвлөгөөг боловсруулж, үндэсний хөгжлийн бодлого, төлөвлөлтийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын саналын хамт тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд өргөн мэдүүлэх” гэж заасан байна.

Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон Монгол Улсын Засгийн газрын 2016-2020, 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг үндэслэн Баян-Өлгий аймгийн 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, аймгийн Засаг даргын 2016-2020, 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр зэрэг бодлогын баримт бичгийг боловсруулжээ.

Аймгийн ИТХ-аас баталсан дэд хөтөлбөрүүд нь аймгийн дунд болон богино хугацааны бодлогын баримт бичигтэй нийцсэн бөгөөд 2018 онд 5, 2019 онд 11, 2020 онд 5, 2021 онд 1, 2022 онд 15, бүгд 37 дэд хөтөлбөрийг боловсруулж, аймгийн Засаг даргын зөвлөлийн хурлаар оруулан хэлэлцүүлж, батлагдсан дэд хөтөлбөрийн жагсаалтыг аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд батлуулахаар хүргүүлж, ажилласан байна.

А.2. Дэд хөтөлбөрүүдэд шаардагдах төсвийг үндэслэлтэй төлөвлөөгүй боловч хэрэгжүүлэх нөхцөл бүрдсэн байна

А.2.1. Дэд хөтөлбөрүүдэд шаардагдах хөрөнгийн эх үүсвэрийг үндэслэлтэй төлөвлөөгүй байна

Аймгийн ИТХ-аас 2018-2022 онд баталсан 37 дэд хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгийн эх үүсвэрийг орон нутгийн төсөв, улсын төсөв, олон улсын байгууллагын санхүүжилт, хандив тусламжийн хөрөнгийн эх үүсвэрээр бүрдүүлэхээр тооцож, нийтдээ 13,763.6 сая төгрөгөөр хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна.

Эрчим хүчний хэмнэлт, үр ашгийг дээшлүүлэх дэд хөтөлбөрийг 11006.5 сая төгрөгөөр хэрэгжүүлэхээр төлөвлөсөн нь баталсан дэд хөтөлбөрийн нийт төсвийн 80.0 хувийг эзэлж байгаа ба бусад 19 дэд хөтөлбөрт 4.7-800.0 сая төгрөгийн хөрөнгө төлөвлөгдсөн байна.

Аймгийн ИТХ-аас 2018-2022 онд баталсан 37 дэд хөтөлбөрийн 21 хөтөлбөрт нь хөрөнгө төлөвлөгдөөгүй, 16 хөтөлбөрт орон нутгийн төсвөөс нийтдээ 295.0 сая төгрөгийн төсөв баталсан байна.

Эдгээр дэд хөтөлбөрүүдээс “Элсэлтийн ерөнхий шалгалтын үр дүнг дээшлүүлэх дэд хөтөлбөр”-т 2018-2022 онд 177.0 сая төгрөгийн, бусад 15 дэд хөтөлбөрүүдэд 2.0-16.0 сая төгрөгийн, нийт дүнгээр 118.0 сая төгрөгийн төсөв баталсан байна.

Дээрх байдлаас үзэхэд дэд хөтөлбөрүүдэд орон нутгийн оролцоог бүрэн тодорхойлоогүй, хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгийн эх үүсвэрийг үндэслэлтэй төлөвлөж батлаагүй байна.

А.2.2. Аймгийн ИТХ-аас баталсан дэд хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө гаргаагүй байна

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 49 дүгээр зүйлийн 49.1-д “Бүх шатны Засаг дарга тухайн Хурлаас гарсан шийдвэрийг хэрэгжүүлэх үүрэгтэй”, 60 дугаар зүйлийн 60.1.3-д аймгийн Засаг дарга “аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас гаргасан шийдвэрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааг хариуцан зохион байгуулж, үр дүнг хариуцах” гэж заасан байна.

Аймгийн Засаг даргын 2021 оны 9 дүгээр сарын 16-ын өдрийн А/751 дүгээр захирамжаар баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх журам”-ын 6.2.3.1, 6.2.3.2-т аймгийн Засаг даргын дэргэдэх агентлаг, харьяа байгууллагууд бодлогын баримт бичгийн биелэлтийг аймгийн ЗДТГ-ын холбогдох хэлтэст, аймгийн ЗДТГ-ын хэлтсүүд бодлогын баримт бичгийн биелэлтийг нэгтгэн боловсруулж, Төрийн захиргааны удирдлагын хэлтэст тайлагнахаар заасан байна.

Аймгийн ЗДТГ-ын Төрийн захиргааны удирдлагын хэлтэс болон холбогдох бусад хэлтсүүд нь аймгийн ИТХ-аас баталсан дэд хөтөлбөрийн хэрэгжилтийг хангуулах үүрэгтэй болохыг дээрх журамд тусгасан боловч дэд хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө боловсруулж батлуулаагүй байна.

Б. АЙМГИЙН ИТХ-ААС БАТАЛСАН ДЭД ХӨТӨЛБӨРҮҮДИЙН ХЭРЭГЖИЛТ ХАНГАЛТГҮЙ БАЙНА

Б.1. Дэд хөтөлбөрүүдийн хэрэгжилт төлөвлөсөн үр дүнд хүрээгүй байна

Б.1.1. Дэд хөтөлбөрүүдэд баталсан санхүүжилтийг дутуу олгосон байна

Аймгийн ИТХ-аас баталсан 37 дэд хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд аймгийн орон нутгийн төсвөөс 2018-2022 онд нийт 295.0 сая төгрөгийн төсөв баталсан байна. Үүнээс: Элсэлтийн ерөнхий шалгалтын үр дүнг дээшлүүлэх дэд хөтөлбөрт 177.0 сая төгрөг, бусад дэд хөтөлбөрүүдэд 118.0 сая төгрөгийн төсөв баталсан байна.

Дэд хөтөлбөрүүдэд 2018-2022 онд гүйцэтгэлээр нийтдээ 227.1 сая төгрөгийн санхүүжилт олгосноос 225.6 сая төгрөгийг зарцуулж, төсвийг 1.5 сая төгрөгөөр хэмнэсэн байна. Энэ нь төлөвлөсөн ажлууд хугацаанд хэрэгжээгүйгээс үлдэгдэл санхүүжилтийг төсөвт төвлөрүүлсэнтэй холбоотой байна.

Дэд хөтөлбөрт орон нутгийн төсвөөс олгосон 227.1 сая төгрөгийн зарлага санхүүжилтийг хэрэгжүүлэгч агентлаг, байгууллагуудын санхүүгийн баримт материалтай тулган шалгаж үзэхэд зориулалтын дагуу зарцуулсан байна.

Хүснэгт №02 Дэд хөтөлбөрүүдийн эх үүсвэрийн төлөвлөлт, олгосон санхүүжилт, зарцуулалт

/сая төгрөгөөр/							
д/д	Он	Хөтөлбөрийн тоо	Төлөвлөсөн эх үүсвэр	Батлагдсан төсөв	Олгосон санхүүжилт	Зарцуулсан дүн	Зөрүү
1	2018	4	0	177.0	138.8	138.8	0.0
2	2019	11	12116.9	6.0	6.0	6.0	0.0
3	2020	5	0	0.0	0.0	0.0	0.0
4	2021	1	4.7	10.0	10.0	10.0	0.0
5	2022	16	1642	102.0	72.3	70.8	1.5
Нийт дүн		37	13763.6	295.0	227.1	225.6	1.5

Эх сурвалж: Аудитын явцад хийсэн судалгаа

Зарим байгууллагууд дэд хөтөлбөрийг тухайн салбар, байгууллагын үйл ажиллагааны чиглэлтэй уялдуулж, нэмэлт төсөв шаардахгүйгээр хэрэгжүүлж ажилласан бөгөөд хэрэгжилтийг нь мөнгөн дүнгээр илэрхийлэх боломжгүй байна.

Дээрх байдлаас үзэхэд ихэнх дэд хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгийн эх үүсвэрийг төлөвлөхдөө орон нутгийн болон бусад эх үүсвэрийн оролцоог тодорхой тусгаагүй, дэд хөтөлбөрт баталсан төсөв нь шаардагдах хэмжээнд хүрээгүй, санхүүжилтийн дутмаг байдлаас дэд хөтөлбөрүүдийн үр дүн төлөвлөсөн хэмжээнд хүрээгүй байхад нөлөөлсөн байна.

Б.1.2. Дэд хөтөлбөрүүдэд төлөвлөсөн арга хэмжээний 59.5 хувийг хэрэгжүүлсэн байна

Аймгийн ИТХ-аас 2018-2022 онд баталж, хэрэгжүүлсэн 37 дэд хөтөлбөрийн хэрэгжилтийг шалгаж үзэхэд 33 дэд хөтөлбөр тодорхой түвшинд хэрэгжсэн, 1 дэд хөтөлбөр хэрэгжээгүй, 3 дэд хөтөлбөрийн хэрэгжих хугацаа болоогүй байна. Тухайлбал:

2019 онд баталсан Залуучуудын хөгжлийг дэмжих хөтөлбөр хэрэгжээгүй, 2022 онд баталсан Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, Шинэ хөдөө, Цахим Өлгий зэрэг дэд хөтөлбөрийн хэрэгжих хугацаа болоогүй байна.

Дэд хөтөлбөрүүдийн хэрэгжилтийг арга хэмжээ тус бүрээр авч үзэхэд төлөвлөсөн 944 арга хэмжээний 562 арга хэмжээг хэрэгжүүлсэн, 301 арга хэмжээ хэрэгжээгүй, 81 арга хэмжээний хэрэгжих хугацаа болоогүй гэж тайлагнасан байна.

Үүнээс үзэхэд нийт төлөвлөсөн арга хэмжээний 59.5 хувийг хэрэгжүүлсэн байна. Дэд хөтөлбөрүүдийн хэрэгжилтийг он оноор авч үзвэл дараах байдалтай байна.Үүнд:

- 2018 онд баталсан 5 дэд хөтөлбөрөөс 4 хөтөлбөр хэрэгжсэн, 1 хөтөлбөрийн хэрэгжилт хангалтгүй байна. 5 дэд хөтөлбөрийн 207 арга хэмжээг хэрэгжүүлэхээс 185 арга хэмжээг хэрэгжүүлж, хөтөлбөрийн хэрэгжилт 90.0 хувьтай,
- 2019 онд баталсан 11 дэд хөтөлбөрийн 6 дэд хөтөлбөр хэрэгжсэн, 4 дэд хөтөлбөрийн хэрэгжилт хангалтгүй, 1 дэд хөтөлбөр хэрэгжээгүй байна. 329 арга хэмжээ хэрэгжүүлэхээс 185 арга хэмжээг хэрэгжүүлэн, 144 арга хэмжээг хэрэгжүүлээгүй, хөтөлбөрийн хэрэгжилт 57.0 хувьтай,
- 2020 онд баталсан 5 дэд хөтөлбөрийг хэрэгжүүлсэн байна. 127 арга хэмжээ хэрэгжүүлэхээс 65 арга хэмжээг хэрэгжүүлж, 62 арга хэмжээг хэрэгжүүлээгүй, хөтөлбөрийн хэрэгжилт 52.0 хувьтай,
- 2021 онд баталсан 1 дэд хөтөлбөрт 18 арга хэмжээ хэрэгжүүлэхээс 13 арга хэмжээг хэрэгжүүлж, хөтөлбөрийн хэрэгжилт 73.0 хувьтай,
- 2022 онд баталсан 15 дэд хөтөлбөрийн 12 дэд хөтөлбөр хэрэгжих шатандаа, 3 дэд хөтөлбөрийн хэрэгжих хугацаа болоогүй байна.12 дэд хөтөлбөрт 182 арга хэмжээ хэрэгжүүлэхээс 117 арга хэмжээг хэрэгжүүлсэн, хөтөлбөрийн хэрэгжилт 65.0 хувьтай байна.

Дээрх байдлаас үзэхэд 2018-2022 онд баталсан 37 дэд хөтөлбөрийн 33 нь хэрэгжсэн гэж тайлагнасан боловч 5 дэд хөтөлбөрийн хэрэгжилт хангалтгүй байна.

Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д “Засгийн газар хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, дүгнэлт гаргана”, 21.2-т “Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх үйл ажиллагааны зорилго нь баримт бичгийн төлөвлөлт, биелэлтэд чанарын үнэлгээ хийх, хэрэгжүүлсэн үйл ажиллагаа, шийдвэр нь үр дүнтэй байсан эсэхэд чанарын үнэлгээ хийх, үр нөлөөг үнэлэхэд оршино” гэж заасан байна.

Аймгийн ЗДТГ-ын Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтсээс 2018-2022 онд баталсан дэд хөтөлбөрүүдийн хэрэгжилтийг дараах байдлаар үнэлсэн байна.Үүнд:

2018 онд хэрэгжсэн 5 дэд хөтөлбөрийн хэрэгжилтийг 70-100 хувьтай, 2019 онд хэрэгжсэн 11 дэд хөтөлбөрийн хэрэгжилтийг 75-100 хувьтай, 2020 онд хэрэгжсэн 5 дэд хөтөлбөрийн хэрэгжилтийг 82.7-96.6 хувьтай, 2022 онд 12 дэд хөтөлбөрийн хэрэгжилтийг 72.9-100 хувьтай гэж үнэлсэн байна.

Аудитын дүнгээс үзэхэд дэд хөтөлбөрүүдийн төлөвлөлт хэрэгжилттэй холбоотой дараах зөрчлүүд илэрлээ. Үүнд:

- 2021 онд хэрэгжсэн дэд хөтөлбөрийн үр дүнд хяналт шинжилгээ, үнэлгээ хийгдээгүй,
- Зарим дэд хөтөлбөрүүдийн зорилт, арга хэмжээг бүрэн тайлагнаагүй,
- Аймгийн ИТХ-аас баталсан дэд хөтөлбөрийн ерөнхий төлөвлөгөөнд тусгасан арга хэмжээний тоо, хөтөлбөрт тусгасан арга хэмжээний тооноос зөрүүтэй,
- Хэрэгжүүлэгч зарим байгууллагаас ирүүлсэн тайлан, Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтсийн хяналт шинжилгээ, үнэлгээний тайланд тусгагдсан арга хэмжээ нь аймгийн ИТХ-аас баталсан дэд хөтөлбөрийн арга хэмжээнээс зөрүүтэй,
- Хэрэгжүүлэгч агентлагууд дэд хөтөлбөрийн биелэлтийг арга хэмжээ тус бүрээр тодорхой гаргаж, үнэлж ирүүлээгүйгээс Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтсээс арга хэмжээ бүрийг гүйцэд үнэлээгүй байна.

Б.2. Дэд хөтөлбөрүүдэд хяналт шинжилгээ, үнэлгээ хийсэн боловч үр дүнг тооцоогүй байна

Б.2.1. Дэд хөтөлбөрүүдийн үр дүнг бодитой тайлагнаагүй байна

Аймгийн Засаг даргын 2021 оны А/751 дүгээр баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх журам”-ын 6.2.3. Тайлагнах шат дараалал хэсгийн: 6.2.3.1-д “Аймгийн Засаг даргын дэргэдэх агентлаг, харьяа байгууллагууд бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт, байгууллагын үйл ажиллагааны тайлан, гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг аймгийн Засаг даргын Тамгын газрын холбогдох хэлтэст журмын 1 дүгээр хавсралтад заасан хугацаанд өөрийн үнэлгээг өгч тайлагнана”,

6.2.3.2-т “Аймгийн Засаг даргын Тамгын газрын хэлтсүүд харьяа агентлаг, байгууллагуудаас ирсэн бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн биелэлтийг нэгтгэн боловсруулж, хэлтсийн даргаар хянуулан Төрийн захиргааны удирдлагын хэлтэст журмын 1 дүгээр хавсралтад заасан хугацаанд тайлагнана”,

6.2.3.5-д “Төрийн захиргааны удирдлагын хэлтэс нь сумдаас ирсэн болон аймгийн Засаг даргын Тамгын газрын хэлтсүүдээс ирсэн бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн биелэлтийг нэгтгэн боловсруулж, хэлтсийн даргаар хянуулан Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтэст журмын 1 дүгээр хавсралтад заасан хугацаанд тайлагнана” гэж заасан байна.

Дэд хөтөлбөр хэрэгжүүлэгч аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлаг, харьяа байгууллагууд ЗДТГ-ын холбогдох хэлтсүүдэд 2018-2022 онд хэрэгжсэн дэд хөтөлбөрүүдийн хэрэгжилтийг тайлагнаж, үнэлгээ өгсөн талаар материалыг аудитын хугацаанд цахимаар ирүүлсэн бөгөөд цаасаар албажуулсан эсэх нь тодорхойгүй байна.

Аймгийн ЗДТГ-ын холбогдох хэлтэс, агентлаг, харьяа байгууллагуудаас 2018-2022 онд хэрэгжүүлсэн дэд хөтөлбөрүүдийг нэгтгэн Төрийн захиргаа

удирдлагын хэлтэст хүргүүлж байсан талаар материалыг аудитад ирүүлээгүй болно.

Үүнээс үзэхэд агентлаг, харьяа байгууллагууд дэд хөтөлбөрүүдийн хэрэгжилтийг үнэлгээ өгч, тайлагнасан эсэх нь тодорхойгүй, аймгийн ЗДТГ-ын холбогдох хэлтсүүд байгууллагуудаас дэд хөтөлбөрүүдийн хэрэгжилтийг авч нэгтгэн боловсруулж, хэлтсийн даргаар хянуулан Төрийн захиргаа удирдлагын хэлтэст албажуулж хүргүүлсэн эсэх нь тодорхойгүй байна.

Төрийн захиргаа удирдлагын хэлтэс нь аймгийн ЗДТГ-ын хэлтсүүдээс ирүүлсэн 2018-2020 оны дэд хөтөлбөрийн хэрэгжилтийг нэгтгэн боловсруулж, хэлтсийн даргаар хянуулж, Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтэст хүргүүлсэн ба 2021 оны дэд хөтөлбөрийн хэрэгжилтийг тайлагнаагүй байна.

Аудитын судалгаагаар аймгийн ИТХ-аас 2018-2022 онд баталсан 37 дэд хөтөлбөрийн 185 зорилтын 944 арга хэмжээний 562 арга хэмжээний хэрэгжилтийг тайлагнасан ба 301 арга хэмжээний хэрэгжилтийг тайлагнаагүй, 81 арга хэмжээний хэрэгжих хугацаа болоогүй байна.

Хүснэгт №03

Дэд хөтөлбөрүүдийн зорилт, арга хэмжээ

Хөтөлбөрт хамрагдах он	Аймгийн ИТХ-ын тогтоолоор баталсан хөтөлбөр тусгагдсан тоо		Харьяа агентлаг, байгууллагуудаас гаргаж ирүүлсэн хэрэгжүүлсэн арга хэмжээний тоо	Зөрүү	Аймгийн ЗДТГ-ын Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтсийн үнэлсэн хөтөлбөрийн арга хэмжээний тоо			
	Зорилтын тоо	Хэрэгжүүлэх арга хэмжээний тоо			2019 он	2020 он	2021 он	2022 он
2018	29	196	171	(25)	4	83	0	32
2019	71	329	185	(144)		76	0	49
2020	22	127	65	(62)		49	0	49
2021	1	18	13	(5)			0	0
2022	62	274	128	(146)		11	0	112
Нийт дүн	185	944	562	(382)	4	219	0	242

Эх сурвалж: Аудитын багийн дэд хөтөлбөрийн хэрэгжилтэд хийсэн судалгаа

Дээрх байдлаас дүгнэж үзэхэд Төрийн захиргаа удирдлагын хэлтэс нь ИТХ-аас баталсан дэд хөтөлбөрүүдийн төлөвлөсөн арга хэмжээ тус бүрээр хэрэгжилтийг үнэлж ирүүлээгүйгээс Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтсээс дэд хөтөлбөрүүдийн төлөвлөсөн арга хэмжээ тус бүрээр үнэлээгүй, хэрэгжүүлэгч агентлагийн ирүүлсэн гүйцэтгэлд үндэслэн үнэлсэн тул дэд хөтөлбөрийн хэрэгжилт, Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтсээс хийсэн үнэлгээнээс зөрүүтэй байна.

Б.2.2. Дэд хөтөлбөрүүдийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн байна

Аймгийн Засаг даргын 2021 оны А/751 дүгээр захирамжийн хавсралтаар баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх журам”-ын 6 дугаар зүйлийн 6.2.3.7-д¹ заасны дагуу Хяналт-шинжилгээ үнэлгээний хэлтэс нь 2018 онд хэрэгжсэн 5 дэд

¹ “Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтэс нь бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэр болон байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтэд журмын дагуу үнэлгээ өгч, хяналт-шинжилгээ, үнэлгээний тайлан, дүгнэлт, зөвлөмж бичнэ”. Хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн тайланг Тамгын газрын даргын зөвлөлөөр хэлэлцүүлж, аймгийн Засаг даргын зөвлөлд танилцуулан Засгийн газрын Хэрэг эрхлэх газар болон бусад холбогдох газарт журамд заасан хугацаанд тайлагнана”

хөтөлбөр, 2019 онд хэрэгжсэн 9 дэд хөтөлбөр, 2020 онд хэрэгжсэн 5 дэд хөтөлбөр, 2022 онд хэрэгжсэн 11 дэд хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт шинжилгээ хийж, үнэлгээ өгсөн байна.

2021 онд хэрэгжсэн дэд хөтөлбөрийн үр дүнд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийгдээгүй байна. Төрийн захиргаа удирдлагын хэлтсээс дэд хөтөлбөр хэрэгжүүлэгч байгууллагуудын тайланг нэгтгэж ирүүлээгүй гэсэн шалтгаанаар үнэлгээ хийгдээгүй байна.

Аймгийн ЗДТГ-ын Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтсээс дэд хөтөлбөрүүдийн хэрэгжилтэд хийсэн үнэлгээний тайлангаас үзэхэд 2019 онд хэрэгжсэн 4 дэд хөтөлбөрийг 70-100 хувиар, 2020 онд хэрэгжсэн 20 хөтөлбөрөөс 15-ыг 58-100 хувиар, 2021 онд хэрэгжсэн 19 хөтөлбөрөөс 5-ыг 82-98.7 хувиар, 2022 онд хэрэгжсэн 27 дэд хөтөлбөрийг үнэлэхээс 19 хөтөлбөрийг дунджаар 86.9-90.3 хувийн хэрэгжилттэй гэж үнэлсэн байна.

Төрийн захиргааны удирдлагын хэлтсээс 2021 оны дэд хөтөлбөрийн хэрэгжилтийн тайланг ирүүлээгүй боловч Хүнс, хөдөө аж ахуйн газраас хэрэгжүүлж байгаа 5 дэд хөтөлбөрийн хэрэгжилтийг Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтэст хүргүүлж үнэлүүлсэн байна.

2022 онд баталсан 3 дэд хөтөлбөрийн хэрэгжих хугацаа болоогүй тул үнэлгээ хийгдээгүй байна.

Засгийн газрын хяналт-шинжилгээ, үнэлгээний мэдээллийн цахим сан буюу unelgee.gov.mn сайтад дэд хөтөлбөрийн хэрэгжилтийг 2019 оноос эхлэн мэдээлж ажилласан байна.

Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1²-д заасны дагуу дэд хөтөлбөрийн хяналт шинжилгээ үнэлгээг Засгийн газрын хяналт-шинжилгээ, үнэлгээний мэдээллийн цахим сан буюу unelgee.gov.mn сайтад мэдээлсэн эсэхийг шалгаж үзэхэд 2020 оны 19 дэд хөтөлбөрийн хэрэгжилтийг мэдээлсэн байна.

Аймгийн ЗДТГ-ын Хяналт-шинжилгээний үнэлгээний хэлтсээс дэд хөтөлбөрүүдийн хэрэгжилтийг үнэлсэн боловч аймгийн Засаг даргын зөвлөлд оруулан, хэлэлцүүлээгүй, үр дүнг тооцоогүй байна.

Б.2.3. Дэд хөтөлбөрүүдийн хэрэгжилтэд хяналт тавьж ажилласан байна

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 52 дугаар зүйлийн 52.1-д "Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга дараах нийтлэг бүрэн эрхийг хэрэгжүүлнэ", 52.1.8-д "Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, эдийн засаг, нийгмийн хөгжлийн үндсэн чиглэлийн биелэлтэд хяналт тавих ажлыг зохион байгуулан биелэлтийг хангуулах арга хэмжээ авах" гэж заасны дагуу аймгийн ИТХ-ын хуралдаанаар баталсан зарим дэд хөтөлбөрүүдийн хэрэгжилтийг хангах зорилгоор дараах ажлуудыг зохион байгуулсан байна. Үүнд:

- 2019 онд баталсан "Эрүүл зан үйлийг дэмжсэн архидалтгүй аймаг Баян-Өлгий", "Соёлтой жолооч" дэд хөтөлбөрийн хүрээнд гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг зохион байгуулан ажилласан.

- Аймгийн ИТХ-аас 2020 онд 23 дэд хөтөлбөрийн хэрэгжилтийн явцыг Хороод болон төлөөлөгчдөд цахимаар танилцуулж, хэрэгжилтэд хяналт үнэлгээ хийсэн.

- Аймгийн ИТХ-ын 2021 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн ээлжит VI хуралдаанаар дэд хөтөлбөрүүдийн хэрэгжилтэд хийсэн хяналт үнэлгээний дүнг хэлэлцэж, 83 хувьтай гэж үнэлсэн байна.

Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлаас дэд хөтөлбөрүүдэд баталсан хөрөнгийг зориулалтын дагуу зарцуулж байгаа эсэхэд жил бүр хяналт тавьж ажилласан байна.

Аймгийн ЗДТГ-аас дэд хөтөлбөрүүдийн хэрэгжилтэд тавьж буй хяналттай холбоотой материал ирүүлээгүй бөгөөд дэд хөтөлбөрүүдийн хэрэгжилтэд тавьж буй хяналтыг хангалтгүй гэж үзэх үндэстэй.

Б.2.4. Дэд хөтөлбөрийн хэрэгжилт, үр дүнгийн талаар олон нийтэд мэдээлж ажилласан байна

Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлаас 2018-2022 онд баталсан 37 дэд хөтөлбөр, түүний хэрэгжилт, үр дүнгийн талаар олон нийтэд ил тод мэдээлсэн эсэхийг шалгаж үзэхэд Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын цахим хуудасны "ТОГТООЛ" цэсэд дэд хөтөлбөрүүдийг олон нийтэд мэдээлж ажилласан байна.

Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын "bayan-olgii.khural.mn" вэб сайтад Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлаас баталсан 37 дэд хөтөлбөрөөс 29 дэд хөтөлбөрийг ил тод мэдээлсэн ба мэдээлсэн байдлын хэрэгжилт 76.3 хувьтай байна.

Хүснэгт №04

Мэдээллийн ил тод байдлын судалгаа

Төсөл, хөтөлбөрийн тоо	Ил тод мэдээлсэн төсөл, хөтөлбөрийн тоо	Ил тод мэдээлээгүй төсөл, хөтөлбөрийн тоо	Хэрэгжилтийн хувь
38	29	9	76.3

Эх сурвалж: Аймгийн ИТХ-ын "bayan-olgii.khural.mn" цахим хуудас

"bayan-olgii.khural.mn" вэб сайтад ил тод мэдээлсэн дэд хөтөлбөрийг мэдээлсэн байдлыг цахим хуудасны хандалт буюу иргэд үзэж сонирхсон байдлыг 2023 оны 10 дугаар сарын 19-ны өдрийн байдлаар судалж үзэхэд 15 дэд хөтөлбөрт 50-100 иргэн, 3 дэд хөтөлбөрт 101-200 иргэн, 3 дэд хөтөлбөрт 201-300 иргэн, 6 дэд хөтөлбөрт 301-400 иргэн, 2 дэд хөтөлбөрт 401-500 иргэн, нийтдээ 5388 иргэн хандсан үзсэн байна.

Аймгийн ЗДТГ-ын Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтэс дэд хөтөлбөрүүдийн хэрэгжилтийг үнэлсэн байдлыг Баян-Өлгий аймгийн Засаг даргын тамгын газрын bayan-olgii.gov.mn вэб сайтад ил тод мэдээлсэн байна.

2019 онд 17, 2020 онд 18, 2022 онд 23 дэд хөтөлбөрийн үнэлгээг bayan-olgii.gov.mn вэб сайтад мэдээлсэн ба 2018, 2021 оны дэд хөтөлбөрийн хэрэгжилтийг мэдээлээгүй байна.

Хяналт- шинжилгээ, үнэлгээний хэлтсээс дэд хөтөлбөрүүдийн хэрэгжилт, үр дүнг олон нийтэд ил тод мэдээлсэн байдлыг он оноор авч үзвэл 66.6 хувьтай хэрэгжүүлсэн байна.

Аймгийн ЗДТГ-ын Төрийн захиргаа удирдлагын хэлтсээс хэрэгжүүлэгч байгууллага, агентлагуудаас дараах 13 дэд хөтөлбөрийн талаар олон нийтэд ил тод мэдээлсэн талаар тайлбар ирүүлсэн. Үүнд:

- Соёлын үйлдвэрлэл дэд хөтөлбөр,
- Гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, дэд хөтөлбөр
- Гэр бүлийн хөгжлийг дэмжих дэд хөтөлбөр
- Англи хэлтэй Өлгийчүүд дэд хөтөлбөр
- Эрүүл хүнс-эрүүл монгол хүн дэд хөтөлбөр болон "Хүнсний ногоо" дэд хөтөлбөр
- Сургуулийн хөгжил-Багшийн хөгжил-Сургалтын чанар дэд хөтөлбөр
- Аймгийн Засаг даргын мөрийн хөтөлбөрт орсон СӨБ-ын "Багшийн хөгжил" дэд хөтөлбөр
- Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих дэд хөтөлбөр
- Цахим Баян-Өлгий аймаг дэд хөтөлбөр
- Ногоон Өлгий дэд хөтөлбөр
- Хоггүй Баян-Өлгий аймаг дэд хөтөлбөр
- Эх хүүхэд, нөхөн үржихүйн эрүүл мэнд
- Эрүүл зан үйлийг дэмжсэн архидалтгүй аймаг Баян-Өлгий-2

Үүнээс үзэхэд 37 дэд хөтөлбөрөөс 13 дэд хөтөлбөрийг олон нийтэд ил тод мэдээлсэн байна.

ДҮГНЭЛТ:

Аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг гаргаж байна.

1. Аймгийн ИТХ-аас дэд хөтөлбөрүүдийг хууль, журамд нийцүүлэн баталсан байна.
2. Аймгийн ИТХ-аас баталсан дэд хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгийн эх үүсвэрийг үндэслэлтэй төлөвлөөгүй байна
3. Аймгийн ИТХ-аас баталсан дэд хөтөлбөрүүдийн хэрэгжилт төлөвлөсөн үр дүнд хүрээгүй байна.
4. Дэд хөтөлбөрүүдийн үр дүнг бодитой тайлагнаагүй, үр дүнг тооцож ажиллаагүй байна.

ЗӨВЛӨМЖ:

Аудитын дүн, дүгнэлт нотлох зүйлст үндэслэн дараах зөвлөмжийг өгч байна.Үүнд:

I. Аймгийн ЗДТГ-ын дарга Б.Мухамед-т:

1. Дэд хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгийн эх үүсвэрийг үндэслэлтэй тооцож, батлуулах.
2. Аймгийн ИТХ-аас баталсан дэд хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө батлуулж ажиллах.
3. Аймгийн ИТХ-аас баталсан дэд хөтөлбөрүүдийн хэрэгжилтэд хяналт тавьж, үр дүнг тооцож ажиллах
4. Дэд хөтөлбөрүүдийн үр дүнг бодитой тайлагнахад анхаарах.

Дээрх зөвлөмжүүдийн биелэлтийг Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газарт 2024 оны 07 дугаар сарын 01-ний өдрийн дотор ирүүлнэ үү.

ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГЫН САНАЛ

Аймгийн ИТХ-ын санал:



БАЯН-ӨЛГИЙ АЙМГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРАЛ

83129 Баян-Өлгий аймаг, Өлгий сум, 5 дугаар баг,
Утас/Факс: (976) 7042 2595,
Вэбсайт: www.bayan-olgi.khural.mn

2023.10.27 № 01/309
танай _____-ны № _____-т

Санал хүргүүлэх тухай

“Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас баталсан, төсөл, хөтөлбөрүүдийн аудитын тайлангийн төсөлтэй танилцаж дараах саналыг хүргүүлж байна. Үүнд:

- Аймгийн ИТХ-аас баталсан дэд хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэхэд шаардагдах бодитой судалгаанд суурилж тооцоолсон хөрөнгийг хөтөлбөр тус бүр тодорхой төлөвлөж өгөх. Санхүүжилтийн дутмаг байдлаас хөтөлбөрийн үр дүн төлөвлөсөн хэмжээнд хүрэхгүй байна.

- Хэрэгжүүлэх хөтөлбөрийн төлөвлөгөөг холбогдох журмын дагуу боловсруулж, батлуулах

Цаашид Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 49 дүгээр зүйлийн 49.4 дэх хэсэгт “Засаг дарга Хурлын шийдвэрийн хэрэгжилтийн талаар жил бүр тухай Хуралд тайлагнана” гэж заасны дагуу дэд хөтөлбөрүүдийн хэрэгжилт, түүний биелэлтийг аймгийн ИТХ-ын хуралдаанаар авч хэлэлцээд дүгнэлт гарган ажиллах болно.

ДАРГА



Ш.ХАВЫЛ

://by documents/blankA4/book.doc

Аймгийн ИТХ-аас ирүүлсэн саналд өгөх тайлбар:

Аймгийн ИТХ-аас баталсан дэд хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгийг бодитой судалгаанд суурилж, тооцоолж төлөвлөх гэсэн санал нь аудитын тайланд тусгагдсан бөгөөд аудитын дүнгээр дэд хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгийн эх үүсвэрийг үндэслэлтэй тооцож, батлуулах талаар зөвлөмж өгөгдсөн.

Аудитаар дэд хөтөлбөрийн хэрэгжилт, үр дүнг хамруулж шалгасан ба хэрэгжүүлэх хөтөлбөрийн төлөвлөгөөний боловсруулалт хамрагдаагүй болно.

Аймгийн ЗДТГ-ын санал:



**БАЯН-ӨЛГИЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР**

83129 Өлгий, Баян-Өлгий аймаг,
Утас/факс: (976) 7042-3264

додг. 10.31 № 3-02/954
танай -ны № - т

**АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН
ГАЗАРТ**

“Аймгийн ИТХ-аас баталсан төсөл,
хөтөлбөрийн хэрэгжилт, үр дүн” сэдвээр хийсэн
гүйцэтгэлийн аудитын тайлангийн төсөлтэй
танилцаж үзлээ.

Цаашид гарсан дутагдлыг арилгуулах талаар
хэлтэс, агентлагийн дарга нарт үүрэг өгч ажиллаж
байна.

Тайлангийн төсөлд тусгах саналгүй болно.

ДАРГА

Б.МУХАМЕД

0108232225



БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ДАРГА ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН ТУШААЛ

2023 оны 11 сарын 02 өдөр

Дугаар А/20

Өлгий

Аудитын тайланг баталгаажуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1 дэх хэсэг, 20 дугаар зүйлийн 20.2, 20.4 дэх хэсэг, Монгол Улсын Ерөнхий аудиторов 2020 оны 12 дугаар сарын 22-ны өдрийн А/106 дугаар тушаалаар баталсан "Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам"-ын хавсралтын 18 дугаар хэсгийн 18.9, Монгол Улсын Ерөнхий аудиторов 2023 оны 10 дугаар сарын 05-ны өдрийн А/102 дугаар тушаалын 4 дүгээр хавсралтын 1-ийн 1.4-д заасныг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. "Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлаас баталсан төсөл, хөтөлбөрүүдийн хэрэгжилт, үр дүн"-д хийсэн гүйцэтгэлийн аудитын тайланг хавсралтаар баталгаажуулсугай.

2. Аудитын тайланг аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, аймгийн Засаг даргад хүргүүлэхийг ахлах аудитор (М.Айнур) үүрэг болгосугай.

3. Аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэх арга хэмжээ авч биелэлтийг 2024 оны 07 дугаар сарын 01-ний дотор ирүүлэхийг аймгийн Засаг даргын тамгын газрын дарга (Б.Мухамед)-д зөвлөсүгэй.

4. Аудитын тайланг баталгаажуулснаас хойш 5 хоногт багтаан аудитын ажлын болон нотлох баримтыг архивын нэгж болгон бичиг хэрэгт хүлээлгэн өгөхийг ахлах аудитор (М.Айнур)-т үүрэг болгосугай.

Х.ЖЕНИСБЕК

